

Бага сургуульд тавтай морил

2026 оны хэвлэл- Монгол хувилбар

Хүүхэд тань Женевийн улсын сургуульд элсэн орж байна. Энэхүү товхимол, улсын сургуулийн үйл ажиллагааг таниулахаас гадна таньд хэрэгтэй энгийн ба хялбар мэдээлэл өгөх болно.

Бага сургууль бол ирээдүйн иргэдийг төлөвшүүлэх эхний алхам юм. Зөв өдөөгчтэй найрсаг энэ орчинд, сурагчид насандаа тохирсон мэдлэг, ур чадварыг хөгжүүлдэг.

Энэхүү товхимолын, видео бичлэгтэй уялдаа бүхий сүүлчийн хуудаснууд нь голчлон бага сургуулийн 1-р ангид хамааралтай мэдээлэл агуулсан байгаа.

Дэлгэрэнгүй мэдээг дараах холбоосоос авна уу :

edu.ge.ch/qr/bienvenue



Женевийн албан ёсны сургууль

Женевийн бага сургууль нь тухайн мужид оршин суугч, хичээлийн жил эхлэхийн өмнөх 7 сарын 31 гэхэд 4 нас хүрсэн хүүхэд болгоныг хүлээн авна.¹

Бага сургууль нь тус бүр 4 жил үргэлжилсэн хоёр үе шаттай (цикль):

- Анхдагч цикл (1- 4 анги) , үүнд 4- 8 насны сурагчид хамаарна
- Дунд цикл (5 - 8 анги) , үүнд 8 -12 насны сурагчид хамаарна.

Женевийн хуулийн дагуу боловсролыг 18 нас хүртэл үргэлжлүүлэн эзэмших ёстой.

Боловсрол нь, чиглүүлэгч цикл болох **дунд боловсролын сургууль¹** дараа, **дунд боловсролын сургууль 2^T** үргэлжлэн олгогдоно.

Сургуулийн амьдрал

Цагийн хуваарь

1- 4-р ангийн хооронд сурагчид долоо хоногийн 4 өдөр (Даваа, Мягмар, Пүрэв, Баасан гарагт) 8:00 - 11:30 хүртэл, мөн 13:30 - 16:00² цаг хүртэл сургуульд явна. 1 ба 2-р ангийн сурагчид хичээлд өглөө 8:45 хүртэл, үдээс хойш 14:00 цаг хүртэл тус тус ирж болно. Завсарлага өглөө нэг, үдээс хойш нэг байна.

5-р ангиас эхлэн Лхагва гарагийн өглөө хичээл орж эхлэнэ.

Хичээлийн цагаар сурагчид багш нарын хариуцлага дор байна. Харин хичээлээс гадуурх цагаар, сурагчид эцэг эхийн хариуцлага дор байх болно.

Сурагч хичээлд заавал явах үүрэгтэй бөгөөд үүнд хичээлийн цагаар явагдаж буй аялал болон төрөл бүрийн бүх арга хэмжээнүүд хамрагдана. Урьдчилан мэдэгдэх боломжгүй шалтгаанаар хичээл таслах тохиолдолд аль болох түргэн хугацаанд сургуульд мэдэгдэнэ үү. Бусад бүх тохиолдолд хүүхдийнхээ хамрагдаж буй сургуулийн вэбсайт дээрх дүрмийг баримтална.

Хүүхдийнхээ сургуулийн вэбсайтруу орох холбоос : edu.ge.ch/primaire (Démarches parents –rubrique Absence)

Хичээлээс гадуур хүлээн авах төв (Parascolaire)

Хичээлийн бүс цагаар хүүхдийг тань зугаат арга хэмжээ явуулдаг мэргэжлийн баг хариуцан хүлээн авах боломжтой.

- Үдийн хоолны завсарлагаар ангидаа буцаж иртлээ үдийн хоол идэж, төрөл бүрийн зугаат арга хэмжээнд оролцох,
- Үдээс хойш өдрийн цай ууж, төрөл бүрийн зугаат арга хэмжээнд оролцох.

Ихэнх сургууль дээр энэхүү хичээлээс гадуур хүлээн авах төвийн үйл ажиллагааг “GIAP”(дүүрэг хоорондын хичээлээс гадуурхи үйл ажиллагааны холбоо) буюу дүүргийн захиргаанууд хамтран зохион байгуулдаг. Энэхүү хичээлээс гадуур хүлээн авах төвийн үйл ажиллагаа нь төлбөртэй. Хичээлээс гадуур хүлээн авах төвийн үйл ажиллагаа нь төлбөртэй бөгөөд урьдчилан бүртгүүлэх шаардлагатай. Дүүргүүд нь эдгээр хүлээн авах төвүүдийг хариуцан ажиллуулдаг.

Хичээлээс гадуур хүлээн авах төвийн дүүргүүдийн бүлгэм (GIAP) : giap.ch/parascolaire

Cartigny, Chêne-Bougeries, Cologny, Laconnex, Soral : мэдээллийг тухайн дүүргийн вэбсайтаас авч болно.

Амралт

Хичээлийн жил 2026 оны 8-р сарын 17-нд нээгдэж 2027 оны 7-р сарын 2-нд хаагдана. Сурагчид албан ёсны амралтын өдрүүд болон сургуулийн амралтаар сургуульд явахгүй. Сургуулийн календарь энд: ge.ch/vacances-scolaires-jours-feries

Хичээлийн хэрэгсэл

Боловсрол үнэ төлбөргүй. Хүүхэд тань шаардлагатай хичээлийн хэрэгслүүдийг үнэ төлбөргүй хүлээн авах болно.

Үүнд сурах бичиг, харандаа, баллуур, хавтас, дэвтэр гэх мэт орно. Өгсөн зүйлсийг хүндэтгэн гамтай хэрэглэх ёстой. Зөвхөн хувийн хэрэглээний эд зүйлсийг эцэг эх хангаж өгнө (углааш, хормогч, биеийн тамирын хувцас гэх мэт). Таньд дэлгэрэнгүй мэдээллийг багш өгөх болно.

¹ Хүүхдийн оршин суух газар болон түүний эцэг эхийн ядаж аль нэгнийх нь оршин суух газрыг хэлнэ. Эцэг эхийн албан ёсны эрх мэдэлтэй хүмүүсийг мөн хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийг эцэг эх гэж тооцно (LIP, 3-р зүйл).

¹ 1-р ангид сурагч, зөвхөн өглөө, хагас цагаар хичээлд явах боломжтой (LIP, 55-р зүйл). Энэ сонголтыг эцэг эх нь бүртгүүлэх явцад мэдэгдэх ёстой.

Зургийн эрх

Сурагчдийн зургийн эрх хууль ёсоор хамгаалагдсан (сургууль танаас хүүхдийн тань зургийг ашиглах зөвшөөрлийг авна).

Сургуулийн зохион байгуулалт

Мэргэжлийн багууд сурагчдын хэрэгцээнд

Сурагчдын сургуулийн амьдралын хүрээнд тулгарч буй бүх төрлийн асуудалд зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилготойгоор мэргэжлийн бага сүлжээ байгуулан ажилладаг.

Анги болгон анги даасан багшийн хариуцлага дор байх бөгөөд та хүүхдийнхээ сурлагатай холбоотой асуудлаар багшаас мэдээлэл авах буюу санал тавих боломжтой.

Мөн сургалтын дэмжлэг үзүүлэх болон дүрслэх урлаг ба биеийн тамирын хичээл дээр тусгай мэргэжлийн багш нар хамтран ажилладаг болно.³

Бусад ажилтангууд (сувилагч, тусгай багш, сургагч нар гэх мэт) сурагчдад болон багш нарт дэмжлэг үзүүлдэг.

Сургуулийг захирал удирдах ба сургуулийн захиргаа нь дэд багш нар болон хүмүүжлийн зохицуулагч ба нарийн бичгээс бүрдэнэ.

Үүний хажуугаар эрүүл мэндийг сурталчилах, өвчнөөс урьдчилан сэргийлэх (нүд, чихний үзлэг, амны хөндийн эрүүл мэнд зэрэг) зорилгоор эрүүл мэндийн ажилтангууд сургууль дээр үе үе ирж үзлэг сурталчилгаа явуулдаг.

Сургалт

Сургалтын хүрээнд хэрэглэгдэж буй үйл ажиллагаанууд нь Швейцарийн романд дүүргүүдийн нэгдмэл буюу романд сургалтын төлөвлөгөөний (Plan d'Etudes Romand-PER) бүрдэл хэсэг юм.

Сургах буюу сурах явцыг дөхөм болгох үүднээс романд сургалтын хэрэгсэлүүд (Moyens d'Enseignements Romands-MER) анги болгонд хэрэгжүүлэгдэж буй. Эдгээр хэрэгсэлүүд нь багшийн сонгосон нэмэлт материалаар баяжуулагдаж болно.

Мөн хичээлээс гадуур музей үзэх, зугаалах, аялах гэх мэт арга хэмжээнүүд сурагчийн боловсролд их ач холбогдолтой байдаг.

PER ба MER -н вэбсайт:

per-mer.ch

PER-н талаар дэлгэрэнгүй мэдээлэл: edu.ge.ch/qr/per-parents

Бага боловсрол дахь сургалтын талаарх вэбсайт: edu.ge.ch/enseignement/ep

Сурлагын түвшинг үнэлэх аргачлал

Сурагчийн сурлагын түвшин хичээлийн жилийн түрш үнэлэгдэнэ. Энэхүү үнэлгээ нь таны хүүхдийн сурлагын талаар баримжаа өгнө.

Үнэлгээ нь явж буй ангиас хамааран янз бүр байна. Тухайлбал, анхдагч цикль буюу 1 - 4 ангийн хооронд сурлагын түвшинг дүнгүй үнэлгээгээр тогтооно. Харин дунд цикль буюу 5 - 8 ангийн хооронд заагдсан хичээл болгоны түвшинг дүнгүй буюу дүнтэй(1 - 6 хүртэл) үнэлгээгээр тогтооно.

Сурлагын дүнгийн хүснэгт гэдэг нь таны хүүхдийн сурлагын түвшинг илтгэж буй албан бичиг юм. Энэхүү хүснэгтийг та хичээлийн хагас жил болгоны төгсгөлд хүлээн авна.

4-р ангиас эхлэн жил болгон бөглөгддөг, **Ерөнхий сургуулын гэрчилгээ (LSO)** гэдэг нь хүүхдийн тань женевиин сургууль дахь замналыг гэрчилж буй албан ёсны баримт юм.

Нийт сурагчиддаа анхаардаг сургууль

Сурагчийн сурлагын амжилтанд эерэг нөлөө үзүүлэхийн тулд сургууль, сурагчийн хэрэгцээ, шаардлага мөн түвшинд тохирсон төрөл бүрийн арга барилтай сургалтын хэлбэрүүд дээр тулгуурлаж ажилладаг бөгөөд үүнд : боловсролын дэмжлэг, хяналттай гэрийн даалгавар, албан бус тохируулгууд, сургалтын тохиргоонууд, хүлээн авах ангиуд, спорт-урлаг-сургалт (sport-art-études SAE), насны чөлөөлөлт, тусгай сургалт зэрэг багтана.

Дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийн вэбсайтаас авна уу: edu.ge.ch/primaire (Enseignement - Сургалтын багийн хэсэг, Тусламж дэмжлэг, Сургуулийн зохицуулалт хэсэг Corps enseignant хэсэг, Soutiens et aménagements scolaires хэсэг) болон Comment l'école soutient votre enfant ? товхимол ge.ch/document/comment-ecole-soutient-votre-enfant

Сургууль ба гэр бүлийн хамтарсан ажиллагаа

Сургууль нь гэр бүлийн хүмүүжлийн үйл ажиллагааг нөхөж өгөх үүрэгтэй. Бид хамтдаа хүүхдийн хөгжил дэвшилд дэмжлэг үзүүлж, сургуулийн боловсролд нь зэрэгээр нөлөөлж чадна.

Анги даасан багш таны холбоо барих гол хүн юм. Багш таньд хүүхдийн тань сурлагын талаар тогтмол мэдээлэл өгөх ба та багштай хүүхдийнхээ сургалттай холбоотой төрөл бүрийн асуудлаар харилцаж болно.²

Хичээлийн жилийн түрш наад зах нь гурван үулзалт буй:

- Найм, эсвэл есдүгээр сард эцэг эхийн хурал,
- Арван сарын сүүл арван нэгэн сарын эх хоёрын хооронд ганцаарчилсан үулзалт,
- Хоёрдугаар улиралийн явцад нэг үулзалт (сургууль болгоны нөхцөл өөр)

Шаардлагатай бол та багшаас, хичээлийн жилийн эхэнд хүүхэд тань хүлээн авсан сурагчийн харилцах дэвтэрээр дамжуулан үулзалт хүсэх боломжтой. Хэрэгцээтэй гэж үзвэл сургууль орчуулагч ирүүлнэ.

Сургууль гэр хоёрыг холбох үүднээс, сурагчийн харилцах дэвтэр болон харилцааны хавтас хоёрыг сурагч байнга гэртээ авчирах болно.

Сурагчдийн эцэг эхийн холбоо

Ихэнх сургууль дээр гэр бүл, сургууль хоорондын харилцан яриаг дэмжих үүднээс сурагчдийн эцэг эхийн холбоо гэж байдаг. (APE)

Хэрэв та бусад эцэг эхтэй танилцах мөн тухайн зөвлөлийн үйл ажиллагааных нь талаар мэдээлэл авахыг хүсвэл энэ зөвлөлд хандаж мөн элсэж болно.

Сурагчдийн эцэг эхийн зөвлөлүүдийн холбоо (FAPEO): fapeo.ch

Хамтрагчдын зөвлөл

Сургууль болон хамтрагчдийн харилцан холбоог хөнгөвчлөх зорилготойгоор сургууль болгон Хамтрагчдын зөвлөлийг үүсгэн байгуулдаг. Сургуулийн захиргаа удирддаг энэ зөвлөл нь Сурагчдийн эцэг эхийн холбоо, дүүргийн захиргаа, Хичээлээс гадуурх үйл ажиллагааны холбоо болон багш нарын багаас бүрдэнэ.

Хичээлийн жилийн явцад зохиогддог үулзалтууд сургуулийн орчин болон сургуультай холбоотой мэдээлэл, зөвлөмж, санаачилга түгээх завшааныг олгодог.

Сургуулийн вэбсайт: edu.ge.ch/primaire (Vie & Règles de l'école –Instances participatives хэсэг)

Гарал үүслийн хэл соёлын хичээл (LCO)

Олон нийгэмлэг болон консулын газрууд үүслийн хэл соёлын хичээлийг, бүртгэлийн үндсэн дээр, тухайн хэлний хэрэглээ ба соёлын харицааг дэмжих үүднээс, санал болгож явуулдаг.

DIP-гийн хамтран ажилладаг байгууллагуудын жагсаалт боловсролын вэбсайт дээр буй; edu.ge.ch/qr/lco

² Түүнчлэн, хүүхдийн боловсролын замналтай холбоотой аливаа чухал шийдвэр гаргахын өмнө эцэг эхийн байр суурийг сонсоно

1-р анги дэлгэрэнгүйгээр

Эдгээр хуудас нь "1,2-р ангид нэг өдөр" видео бичлэгтэй уялдаатай нэмэлт мэдээлэл

ogn.edu.ge.ch/qr/bienvenue



Хүүхэд бага сургуульд орно гэдэг нь гэр бүлийг бүхлээр нь өөрчлөлтөнд оруулдаг онцлог үе.

Хамтдаа бид хүүхэдийн, хүсэлийнхээ дагуу хүрэлцэн ирж суралцах сонирхолийг өдөөж чадна.

Эхний хоёр жилийн зорилт нь сурагч болгоныг хүлээн авч дагалдах, аман яриаг нь хөгжүүлэх (ойлгох, илэрхийлэх), тоглоом наадгайгаар дамжуулан бага багаар сургалтанд оруулах, хялбар бодлого шийдвэрлэх, дасгал хийх, ой санамж хөгжүүлэх зэрэгт оршино.

Багш нарын багын дэмжлэгээр мөн ангийнхантайгаа харилцаанд орсноор таны хүүхэд:

- Шинэ орчинг нээж, түүндээ дасан зохицох,
- Бусадтай нээлттэй нийтэч болж анги ба сургууль дотор харилцаанд орох,
- Багшийн анхаарлыг бусадтай хуваалцаж сурах,
- Тоглоом наадгай, туршлага дээр тулгуурлан шинэ мэдлэг ба үр чадварыг олж авах болно.

Сургуульд суралцах нөхцөл гэж байхгүйгээс гадна хүүхдийг урьдчилан, сургуульд бэлтгэх ямар ч шаардлага үгүй.

Гэвч өдөр тутмынхаа амьдралд бие даах байдлыг нь зоригжуулж өгснөөр та хүүхэддээ өөртөө итгэлтэйгээр сургуульд орох боломжийг нээж өгнө.

Сурах явцдаа хүүхэд тань багш нарын зүгээс байнгын дэмжлэг хүлээн авах ба та багш нартай нягт холбоотой хамтран ажиллана. Зарим 1,2-р ангиудад долоо хоногийн зарим өдөр туслах багш хамтран ажиллана.

Эхний хоёр жилийн турш сургалт голчлон дараах зүйлс дээр суурилана:

- **Хамт олонтой зохицон суралцах чадвар** ; хүүхэд тань ангийн болон сургуулийн дүрмийг мөрдөж сурна. (тоглоомын талбайн дүрмийг баримтлах, бусдыг хүндлэх, өөрийнхөө ээлжийг хүлээх г.м.)
- **Хүрээлэн буй орчин ертөнцийг ойлгох мэдлэгийг суулгах** ; боловсролын үндсэн төслийн төрөл бүрийн салбарыг хамарсан арга хэмжээ, үйл ажиллагаан дээр тулгуурлана.
- **Сурах арга барил төлөвшүүлэх** ; мэдлэг олох, төлөвших мөн үр чадвар эзэмших боломжийг нээж өгнө (сонсох, хамтран ажиллах, санал бодлоо илэрхийлэх, анхаарлаа төвлөрүүлэх, цээжлэх, төлөвлөх, ямар нэг асуудалд зөв шийдэл сонгох г.м.).

Хичээлийн явцад төрөл бүрийн аргачлалыг санал болгодог, тухайлбал:

- *Тогломоор дамжуулан суралцах үе* нь бүтээх, хамтрах, харилцах чадварыг хөгжүүлэх, нөхцөл байдалд тохируулж биеэ зөв авч явж сурах боломжийг олгоно.
- *Солилцооны үе* нь яриаг хөгжүүлэх, тайлбар өгөх, зөрчилдөөн шийдвэрлэхээс гадна бусдыг сонсож санал бодлыг нь харгалзан үзэж чаддаг чадвартай болгоно.
- Багш болон ангийнхантайгаа харилцах замаар *шинэ үр чадвар нээж олох үйл ажиллагаа*.
- Сурах чадварыг бататгах, бие даасан байдлыг хөгжүүлэх *дасгалын үйл ажиллагаа* (энгийн зааварчилгааг бие даан дагах, жижиг бүлгээр ажиллах г. м).

Сургалт анги дотор буюу сургуулийн бусад байр болон гадаа ч явагдаж болно (тоглоомын өрөө, биеийн тамирын заал, усан сан, номын сан, тоглоомын талбай, театр, музей, цэцэрлэгт хүрээлэн).

Хичээлийн жил эхлэхээс өмнө хийх зүйлс:

- GIAP-аас санал болгож буй хичээлээс гадуур үйл ажиллагаанд тухайн төвийн хуанлийн дагуу бүртгүүлнэ (сургуулийн edu.ge.ch/primaire цахим хуудас дахь тохирох холбоост хандана уу).
- Ихэнх дүүргийн захиргаан дээр: эцэг эх хүүхдэд дэмжлэг үзүүлдэг салбар гэж бий (жш: *Bientôt à l'école!* " *биянтуалекол* " Иргэний харьяаллын газар : bientotalecole.ge.ch)
- Мэдээллийн зориулалттай уулзалт цуглаан, анги үзэх г.м (сургууль тус бүрийн дүрмийн дагуу)
- 7 сарын явцад: хичээлийн жилийн нээлттэй холбоо бүхий захидал (хэрэгтэй мэдээлэл)

Хичээлийн жил эхлэхээс өмнө нүүх тохиолдолд та хүүхдээ бүртгүүлсэн сургуулийн захиргаанд энэ тухайгаа мэдэгдэх ёстой.

Сургуулийн амралт

Жөн жөнөвүэ

2026 оны 9 сарын 10 Пүрэв

2-р сарын амралт

2027 оны 2 сарын 15 Даваагаас 2 сарын 19 Баасан хүртэл

Пүн де ласонсиун

2027 оны 5 сарын 6 Пүрэв ба
5 сарын 7 Баасан

Намрын амралт

2026 оны 10 сарын 19 Даваагаас
10-р сарын 23 Баасан хүртэл

Өндөгний баяр

2027 оны 3 сарын 26 Баасанаас
4 сарын 9 Баасан хүртэл

Понтокут

2027 оны 5 сарын 17 Даваа

Зул сар ба Шинэ оны баяр

2026 оны 12 сарын 24 Пүрэв
2027 оны 1 сарын 8 Баасан хүртэл

Зуны амралт

2027 оны 7 сарын 5 Даваагаас